

### 30 МОСЕ БОЛОН ШАТАЖ БУЙ БУТ

#### 30.1 Ариун газар, гутлаа тайлаад шатаж буй бутны дэргэд Бурхантай уулз

<sup>1</sup>Мосе өөрийн хадам эцэг Мидианы тахилч Иетрогийн хонин сүргийг хариулж байв. Тэр сүргийг цөлийн баруун талд аваачиж, Бурханы уул Хорebt хүрчээ. <sup>2</sup>ЭЗЭНий тэнгэр элч бутан дотроос галын дөл дунд түүнд үзэгдэв. Үзэгтүн, бутанд гал дүрэлзэж байсан боловч бут шатахгүй байгааг Мосе харлаа. <sup>3</sup>Тэгээд Мосе -Бут яагаад шатахгүй байгаа энэ гайхамшигт үзэгдлийг одоо би очиж харах ёстой гэлээ.

<sup>4</sup>Түүний харахаар эргэхийг ЭЗЭН хараад, бутны дундаас Бурхан түүнийг дуудан -Мосе! Мосе! гэсэнд, тэр -Би энд байна гэж өгүүлэв. <sup>5</sup>Тэгтэл Тэр-Наашаа бүү ойрт!

Чиний зогсож байгаа газар бол ариун газар учраас чи хөлөөсөө шаахайгаа тайл гэж айлдав. <sup>6</sup>Мөн -Би чиний эцгийн Бурхан, Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан, Иаковын Бурхан гэж айлдсанд,

Мосе Бурханыг үзэхээс айж, нүүрээ нуув. <sup>7</sup>ЭЗЭН -Египетэд байгаа Өөрийн ард түмний зовлонг Би сайтар харж, дарлагчдаас нь болсон тэдний хашхирааныг сонслоо. Би тэдний зовлонг мэдсэн. ( Египетээс гарсан нь 3:1-7 АБ 2004 )

[ ] Тэрхүү шатаж буй бут яагаад ариун газар болон гутал тайлах шаардлагатай газар болсон талаар та мэдэх үү ?

[ ] Та амьд, ариун, хүчит Бурханыг харах зохистой юу?

#### 30.2 Тэдний уйлахыг сонссон

<sup>7</sup>ЭЗЭН-Египетэд байгаа Өөрийн ард түмний зовлонг Би сайтар харж, дарлагчдаас нь болсон тэдний хашхирааныг сонслоо. Би тэдний зовлонг мэдсэн. <sup>8</sup>Тиймээс тэднийг египетчүүдийн гараас чөлөөлж, тэр газраас гарган, канаан, хит, амори, периз, хиви, болон иебусчуудын газар болох сүү балаар бялхсан сайхан уудам нутаг уруу аваачихаар Би бууж ирлээ.

<sup>9</sup>Үзэгтүн, Израилийн хөвгүүдийн хашхираан Надад хүрсэн. Цаашилбал египетчүүд тэднийг хэрхэн дарлаж байгааг ч Би харсан. <sup>10</sup>Тиймээс, одоо нааш ир. Би чамайг Фараон уруу илгээж, чамаар Өөрийн ард түмэн болох Израилийн

хөвгүүдийг Египетээс авчруулъя гэв. <sup>11</sup>Гэвч Мосе Бурханд -Фараон уруу очиж, Израилийн хөвгүүдийг Египетээс гаргах гэдэг би хэн юм бэ? гэж хэлсэнд, <sup>12</sup>Тэр -Би чамтай заавал хамт байна. Чи ард түмнийг Египетээс гарган авчраад, та нар энэ ууланд Бурханд мөргөнө.

Энэ нь чамд Миний чамайг илгээсний тэмдэг болно гэж айлдав. <sup>13</sup>Тэгэхэд Мосе Бурханд -Хараач. Би Израилийн хөвгүүд уруу очиж, тэдэнд “Та нарын өвөг дээдсийн Бурхан намайг та нар уруу илгээв” гэж хэлэхэд, тэд надаас “Түүний нэр хэн бэ?” гэж асуувал, би тэдэнд юу гэж хэлэх вэ? гэв. ( Египетээс гарсан нь 3:7-13 АБ 2004 )

<sup>6</sup>Иерусалим аа, Би чиний хэрмэн дээр манаач нарыг тавив. Тэд бүх л өдөржин, бүх л шөнөжин хэзээ ч дуугаа хураахгүй. ЭЗЭНийг дурсагч аа, бүү амрагтун.<sup>7</sup>Тэр Иерусалимыг босгож, байгуулж газрын магтаал болгох хүртэл нь Түүнд бүү амралт өгөгтүн. ( Исаиа 62:6-7 АБ 2004 )

[ ] Та хавчлагад өртсөн хүмүүсийг Түүний хамгаалалтанд байхын төлөө залбирдаг уу?

[ ] Тэдний төлөө хэрхэн залбирахаа та мэдэх үү?

[ ] «Амралтгүй» байх гэдэг нь юу гэсэн үг болох үүнийг хэрхэн хийх вэ?

### 30.3 ДҮРВЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тэр хэн бэ, яагаад Тэр үүнийг хийж байгаа юм бэ? Яагаад одоо, би юу хэлэх ёстой, хэн намайг сонсох вэ, тэд ямар хариу өгөх бол...

<sup>14</sup>Бурхан Мосед -Би бол “Би байдаг” гэв. Тэгээд Тэр - Израилийн хөвгүүдэд чи “Би байдаг” намайг та нар уруу илгээв” гэж хэл гэлээ. <sup>15</sup>Цааш нь Бурхан Мосед -Израилийн хөвгүүдэд чи “Та нарын өвөг дээдсийн Бурхан, Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан, Иаковын Бурхан болох ЭЗЭН намайг та нар уруу илгээв” гэж хэл. Энэ бол мөнхөд Миний нэр бөгөөд үеийн үед Миний дурсгалт нэр юм. <sup>16</sup>Явж, Израилийн ахмадуудыг хамтад нь цуглуулан “Та нарын өвөг дээдсийн Бурхан, Абрахам, Исаак, Иаковын Бурхан ЭЗЭН надад үзэгдэн “Би та нарыг үнэхээр анхаарч, Египетэд та нарт юу тохиолдсоныг харав. <sup>17</sup>Тиймээс та нарыг Египетийн зовлонгоос гаргаж, сүү балаар бялхсан нутаг канаан, хит, амори, периз, хиви, иебусчуудын нутаг уруу аваачна гэж Би

айлдлаа” гэж хэл. <sup>18</sup>Тэд чиний үгийг сонсоно. Чи Израилийн ахмадуудтай хамт Египетийн хаан уруу очоод “Еврейчүүдийн Бурхан ЭЗЭН бидэнтэй уулзсан. Тиймээс одоо бид өөрсдийн Бурхан ЭЗЭНд тахил өргөхийн тулд цөл уруу гурван өдрийн аянд явахыг бидэнд зөвшөөрөөч!” гэж хэл. <sup>19</sup>Харин хүчит мутраар цохихоос нааш Египетийн хаан та нарын явахыг зөвшөөрөхгүйг Би мэдэж байна. <sup>20</sup>Би Өөрийн мутраа сунгаж, Египетийн голд үйлдэх бүхий л гайхамшгуудаараа тэр улсыг цохисны дараа тэр та нарыг явуулна. <sup>21</sup>Би египетчүүдийн нүдэн дээр энэ ард түмэнд хайр энэрлийг соёрхох болно. Та нар явахдаа гар хоосон явахгүй. <sup>22</sup>Харин эмэгтэй хүн бүр хөршөөсөө болон гэрт нь амьдардаг эмэгтэйгээс алт, мөнгөн эдлэл ба хувцас гуйж аваад, хөвгүүд охиддоо өмсгөж зүүлгэ. Ингэж та нар египетчүүдийг тонох болно гэв. ( Египетээс гарсан нь 3:14-22 АБ 2004 )

[ ] БИ БАЙДАГ – н дэлхий дээрх төлөвлөгөөнүүд Түүний төлөвлөсний дагуу бүтнэ гэдэгт та итгэдэг үү ? Та Түүний төлөвлөсний эсрэг биш, харин төлөвлөсний дагуу ажиллаж байна уу?

[ ] Зөвхөн эцэг Абрахам гээгүй яагаад гурван нэр дурдсаныг та мэдэх үү ?

[ ] Бурхан итгэмжит бөгөөд Амласан зүйлээ биелүүлдэг ч та өөрийн үүргийг биелүүлэх ёстой. Та өөрийн хийх ёстойгоо мэдэх үү ?

### 30.5 ЦӨЛ

<sup>34</sup>Тэгтэл хурлын майхныг үүл бүрхэн, ЭЗЭНий цог жавхлан асрыг дүүргэлээ. <sup>35</sup>ЭЗЭНий цог жавхлан асрыг дүүргэж, дээр нь үүл багшран суусан тул Мосе хурлын майхан уруу орж чадахгүй байв.

<sup>36</sup>Тэдний бүх аяны туршид үүл асрын дээрээс дээш өргөгдөх болгонд Израилийн хөвгүүд хөдлөн, <sup>37</sup>харин үүл дээш өргөгдөхгүй бол дээш өргөгдөх өдрийг хүртэл тэд хөдөлдөггүй байлаа.

<sup>38</sup>Учир нь тэдний бүх аяны туршид Израилийн бүх гэрийн нүдэн дээр ЭЗЭНий үүл өдөр нь асрын дээр байж, шөнө нь

үүлэн дотор гал үзэгдэв. ( Египетээс гарсан нь 40:34-38 АБ 2004 )

Бурханыг эсэргүүцнэ гэдгийг нь мэдэж байсан ч Амласан газрыг эзэмших гэсэн амлалтаа биелүүлсэн. Тэдний үр удамд амлалтаа хэлсээр ирсэн. Түүгээр дамжуулан аврал, өршөөл ирнэ.

<sup>43</sup>Би тэнд Израилийн хөвгүүдтэй уулзах бөгөөд энэ газар Миний цог жавхлангаар ариусгагдана. <sup>44</sup>Би хурлын майхан хийгээд тахилын ширээг ариусгана. Надад тахилч нар болж үйлчлэх Аарон хийгээд түүний хөвгүүдийг Би ариусгана. ( Египетээс гарсан нь 29:43 АБ 2004 )

[ ] Та цөл дэхь шалгалтыг давсан эсэхээ мэдэх үү ?

[ ] Сонгогдсон ард түмэн яагаад цөлөөр дамжин өнгөрөх хэрэгтэйг та мэдэх үү?

## НҮГЭЛТ ҮНДЭСТЭН

### 30.6 Израилийн төлөөх Эцгийн хайр

<sup>25</sup>Би, зөвхөн Би Өөрийнхөө төлөө чиний хилэнцийг арилган, чиний нүглийг дурсахгүй. <sup>26</sup>Надад сануулагтун. Өөрсдийн хэргээ хамтран шүүн хэлэлцье. Зөв гэдгээ батлахын тулд чи учир шалтгаанаа хэлэгтүн. <sup>27</sup>Чиний анхны эцэг нүгэл үйлдэж, чиний зуучлагч нар Миний эсрэг хилэнц үйлдэв. <sup>28</sup>Тийм учраас Би ариун газрын чинь тэргүүлэгчдийг бузарлаж, Иаковыг хараагдахаар, Израилийг дооглуулахаар өгнө”. ( Исаиа 43:25-28 АБ 2004 )

<sup>5</sup>Би бол ЭЗЭН. Өөр байхгүй. Надаас өөр Бурхан байхгүй. Хэдийгээр чи Намайг танихгүй ч, Би чамайг хүчирхэгжүүлнэ. ( Исаиа 45:5 АБ 2004 )

<sup>12</sup>Үнэн зөвөөс алс байгч, хатуу зүрхтнүүд Намайг сонсогтун. <sup>13</sup>Би Өөрийн үнэн зөвийг ойртуулна. Энэ нь хол биш байна. Миний аврал удахгүй. Би Сионд авралыг соёрхож, Израильд Өөрийн алдрыг өгнө. ( Исаиа 43:12-13 АБ 2004 )

[ ] Та Түүний оршихуйг амьдралдаа байлгахыг хүсэж байна уу?

[ ] Та энэ дэлхийн бүх бурхдын хувь заяаг мэдэх үү ?

[ ] Та Түүний зөвт байдлын дагуу үйлдэл хийдэг үү?

### 30.7 Үүрд буруутгахгүй

<sup>16</sup>Би мөнхөд буруутгахгүй, үргэлж ууртай байхгүй. Учир нь сүнс болон Миний бүтээсэн амьсгал нь Миний өмнө сул дорой болно. ( Исаиа 57:16 АБ 2004 )

<sup>12</sup>Хүлээгдсэн итгэл найдвар зүрхийг өвчлүүлдэг бол Биелсэн хүсэл амийн мод болой. ( Сургаалт үгс 13:12 АБ 2004 )

<sup>12</sup>Яагаад гэвэл Би тэдний гэм бурууд өршөөнгүй хандана. Би цаашид тэдний нүглүүдийг дурсахгүй” ( Еврей 8:12 АБ 2004 )

[ ] Шүүлтийн дунд ч Түүний нигүүлслийг дурсан санахын төлөө залбирдаг уу?

### 30.8 БУРХАН ӨӨРИЙНХӨӨ АРД ТҮМНИЙ ТӨЛӨӨ БОЛОМЖТОЙ БҮХНИЙГ ХИЙСЭН

<sup>1</sup>“Би одоо хайртдаа зориулж, Түүний усан үзмийн талбайн тухай хайртынхаа дууг дуулъя. Миний хайрт маш үржил шимтэй гүвээн дээр усан үзмийн талбайтай байсан юм.<sup>2</sup>Тэр эргэн тойрныг нь малтаж, чулуунуудыг нь зайлуулаад, шилмэл усан үзмийг суулгаж, талбайн голд цамхаг босгоод, түүний дотор усан үзмийн шахуурга суулгаж гэнэ. Тэгээд Тэр сайхан усан үзэм гарна гэж хүлээж байтал зэрлэг жимс ургажээ.

<sup>3</sup>Одоо Иерусалимын оршин суугчид, Иудагийн эрчүүд ээ! Би болон Миний усан үзмийн талбайн хоорондохыг шүүгтүн!

<sup>4</sup>Усан үзмийн талбайдаа Миний хийгээгүй өөр юуг Би хийх ёстой байсан юм бэ? Сайн усан үзэм гарна гэж Би хүлээж байхад яагаад зэрлэг жимс гарсан бэ? <sup>5</sup>Одоо Би Өөрийн усан үзмийн талбайд юу хийх гэж байгаагаа та нарт өгүүлбэ. Би түүний хайс шивээг авч хаяад, шатаана. Би ханыг нь нурааж талхлагдсан газар болгоно.<sup>6</sup>Би талбайг эзгүйрүүлэн хаяад, тайрч арчлахгүй, зээтүүдэхгүй. Харин өргөст бут, үүргэнэ ургана. Түүн дээр бороо бүү оруул гэж Би үүлэнд тушаана”.<sup>7</sup>Яагаад гэвэл түмэн цэргийн ЭЗЭНий усан үзмийн талбай бол Израилийн гэр,Түүний таалан соёрхдог ургамал нь

Иудагийн эрчүүд юм. Тэр шударга үнэнийг эрсэн боловч, цус урсгахыг үзэв. Зөвийг эрсэн боловч, зовлонг дууг сонсжээ. ( Исаиа 5:1-7 АБ 2004 )

<sup>19</sup>Хэн нэг нь хаанчлалын тухай үгийг сонссон авч үл ойлговол хорон нэгэн нь ирж, түүний зүрхэнд юу суулгагдсаныг булаан авдаг байна. Энэ нь зам хавиар унагсад юм. ( Матай 13:19 АБ 2004 ) Яагаад сайн үр тариа ургаагүй гэдгийг та мэдэх үү?

## ҮҮНЭЭС АГУУ ХАЙР ГЭЖ ҮГҮЙ

### 30.9 Төгс хайр, баяр баясгалан

<sup>9</sup>Эцэг Намайг яаж хайрласан шиг Би бас та нарыг хайрласан. Миний хайр дотор байгтун. <sup>10</sup>Би Эцэгийнхээ тушаалыг сахиж, Түүний хайр дотор байдгийн адил, та нар Миний тушаалыг сахивал Миний хайр дотор байх болно.

<sup>11</sup>Миний баяр баясгалан та нар дотор байж, та нарын баяр баясгалан нь дүүрэн болохын тулд энэ бүхнийг Би та нарт хэлэв. <sup>12</sup>Би та нарыг яаж хайрласан шиг та нар бие биеэ хайрлагтун. Энэ бол Миний тушаал.

<sup>13</sup>Нөхдийнхөө төлөө амиа зориулахаас өөр агуу хайр байхгүй. <sup>14</sup>Хэрэв та нар Миний тушаасныг хийвэл, та нар Миний нөхөд мөн. <sup>15</sup>Би та нарыг боолууд хэмээн дахиж дуудахгүй. Учир нь эзнийхээ юу хийж байгааг боол мэддэггүй юм. Харин Би та нарыг анд нөхөд хэмээн дуудав. Учир нь Би Эцэгээсээ сонссон бүхнээ та нарт мэдүүлсэн билээ.

<sup>16</sup>Та нар Намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон. Та нарыг явж, жимс ургуулж, та нарын үр жимс үүрд байгаасай гэсэндээ Би та нарыг томилсон. Ингэснээр Миний нэрээр та нар Эцэгээс юуг ч гуйсан Тэр та нарт өгөх юм. <sup>17</sup>Би та нарт үүнийг тушаая. Та нар бие биеэ хайрлагтун. ( Иохан 15:9-17 АБ 2004 )

<sup>1</sup>Фарисайчуудын дотор Никодем гэгч хүн байлаа. Тэр иудейчүүдийн удирдагчдын нэгэн байв. <sup>2</sup>Тэр хүн Есүс дээр шөнөөр ирээд Түүнд -Рабби, Таныг Бурханаас ирсэн багш гэдгийг бид мэднэ. Учир нь Бурхантай хамт байхгүй л бол, хэн ч Таны үйлддэг тэмдгүүдийг үйлдэж чадахгүй гэв. <sup>3</sup>Есүс хариуд нь -Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн дээрээс эс

төрнө, тэр хүн Бурханы хаанчлалыг үзэж чадахгүй гэхэд<sup>4</sup>Никодем Түүнд -Настай болсон атлаа хүн хэрхэн төрөх билээ? Хүн эхийн хэвлийд хоёр дахиа орж, төрж чадна гэж үү? гэлээ.

<sup>5</sup>Есүс -Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалд орж чадахгүй.<sup>6</sup>Махан биеэс төрсөн нь махан бие, Сүнснээс төрсөн нь сүнс болой.<sup>7</sup>“Чи дээрээс төрөх ёстой” гэж Би чамд хэлсэнд бүү гайх.<sup>8</sup>Салхи дуртай газраараа үлээдэг. Чи дууг нь сонсовч, салхийг хаанаас ирж, хааш оддогийг мэддэггүй. Сүнснээс төрсөн хүн бүр үүнтэй адил байдаг гэж айлдав.

<sup>9</sup>Никодем Түүнээс -Ийм юм яаж байх юм бэ? гэж асуулаа.<sup>10</sup>Есүс -Чи Израилийн багш атлаа үүнийг ойлгохгүй байна гэж үү? <sup>11</sup>Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Бид мэдсэнээ ярьж, үзсэнээ гэрчилж байхад та нар бидний гэрчлэлийг хүлээн авдаггүй.<sup>12</sup>Хэрэв Би чамд газрын юмсыг ярихад чи итгэхгүй бол, тэнгэрийн юмсыг Би яривал, чи яаж итгэх юм бэ? <sup>13</sup>Тэнгэрээс доош бууж ирсэн Хүний Хүүгээс өөр тэнгэрт дээш гарсан хүн нэг ч байхгүй.

<sup>14</sup>Мосе цөлд тэр могойг өргөсөн шиг, Хүний Хүү ч бас өргөгдөх ёстой.<sup>15</sup>Энэ нь Түүнд итгэгч хүн бүрийг мөнх амьтай байлгахын тулд билээ.<sup>16</sup>Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм.<sup>17</sup>Бурхан Өөрийн Хүүгээ ертөнцийг яллахын тулд биш, харин Түүгээр дамжуулан ертөнцийг аврахын тулд ертөнц уруу илгээсэн билээ.<sup>18</sup>Түүнд итгэдэг хүн яллагдахгүй. Харин үл итгэдэг хүн аль хэдийн яллагдсан.

Учир нь тэр хүн Бурханы цорын ганц Хүүгийн нэрэнд итгээгүй юм.<sup>19</sup>Тэрхүү яллалт ийм билээ. Гэрэл ертөнцөд ирэхэд хүмүүсийн үйлс бузар муу учир тэд харанхуйг гэрлээс илүү хайрласан юм.<sup>20</sup>Учир нь өөрийнх нь үйлс ил гарчих вий гэж бузрыг үйлдэгч хүн бүр гэрлийг үзэн ядаж, гэрэл уруу гарч ирдэггүй.<sup>21</sup>Харин үйлс нь Бурханы дотор үйлдэгдсэн гэдгийг ил харуулахын тулд үнэнийг үйлдэгчид гэрэл уруу ирдэг гэлээ. ( Иохан 3:1-21 АБ 2004 )

[ ] Та нар Христ дотор хэрхэн байхыг мэддэг үү? Энэ талаар Есүс юу гэж амласан бэ?

Сайн мэдээ бол сайн мэдээнд итгэдэг тэдний хувьд авралын хүч харин үл итгэгчидийн хувьд хүмүүст саад болдог. Та сайн мэдээнд итгэдэг үү?

<sup>16</sup>Би сайн мэдээнээс ичихгүй. Яагаад гэвэл тэр нь итгэгч хүн бүрийг, юуны түрүүнд Иудей, мөн түүнчлэн Грек хүнийг авралд хүргэх Бурханы хүч мөн. ( 1 Коринт 1:18 АБ 2004 )

[ ] Та Ариун Сүнсийг хүлээн авсан уу?

[ ] Та дайснаа хэрхэн хайрлахыг мэдэх үү ?

[ ] Та диваажингаас ирсэн эсвэл диваажин явсан хэн нэгнийг мэдэх үү?

[ ] Таньд сайн мэдээ хямдхан байна уу?